

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хуулийн төслийн талаар

1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Төрийн бүтээмжийн сэргэлт” хэсгийн 6.3.5-д Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх гэж, ингэснээр дотоодоос хангах бололцоогүй байгаа ажиллах хүчийг гадаадаас авах боломжийг бүрдүүлсэн байх үр дүнд хүрэхээр тусгасан.

Түүнчлэн урт хугацааны бодлогын хувьд, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.3.2-т “Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшсөн байна.” гэж, мөн 4.1.5-д “Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадвар дээшилсэн байна.” гэж, мөн 5.1-д “Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлсэн байна.” гэж түүнчлэн 5.2.5-д “Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хувийн өмчийг хамгаалах эрх зүй, бодлогын орчин бүрдэнэ.” гэж тус тус заасан нь бизнес эрхлэгч, тэр дундаа ажиллах хүчний хомсдолд орсон бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг ажиллах хүчний хомсдолд орсныг цаг алдалгүй таслан зогсоож, дэмжихийг чиглүүлж байна.

2. Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг анхдагч хуулийн төсөл ... боловсруулахад хийнэ.” гэж, мөн тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, эсхүл хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаанд тус үйл ажиллагааг анхдагч хуулиар зохицуулах шаардлагатай гэж тодорхойлсон болно.

Ийнхүү дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хийсэн урьдчилан тандан судалгаанд тусгагдсан хэрэгцээ, шаардлагад үндэслэн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

Уул уурхай, газрын тос олборлох үйл ажиллагаанаас бусад эдийн засгийн үйл ажиллагааны салбарт 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал

¹ Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй бөгөөд энэ хугацаанд ажил олгогчийг гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх зохицуулалтыг хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгасан болно. Учир нь энэхүү зохицуулалтыг бий болгох дараах хэрэгцээ, шаардлага үүссэн байна. Үүнд:

1/Ажиллах хүчний хомсдол 2030 он хүртэл үргэлжлэх тооцоолол байгааг харгалзан үе шаттай бодлогын арга хэмжээ авах буюу ирэх 2-3 жилд ажлын байрны төлбөрөөс чөлөөлж, тус хугацаанд гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, ингэснээр хувийн хэвшлийг дэмжиж ажиллах хүчний хомсдолоос гарахад чиглэх бодлогын зохицуулалт шаардлагатай болсон. Хуулиар тогтоосон ажлын байрны төлбөрийн хэмжээ нь өндөр байгаа нь ажил олгогч шаардлагатай ажлын байрандаа дотоодоос ажилтан авах боломжгүй ч гадаад ажилтан авч чадахгүйд хүрч, улмаар ажиллах хүчний хомсдолд орсон шалтгаан байж болох талаар хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланд дурдсан;

2/Ажил олгогчид ажлын байрны төлбөрөөс гадна маш олон зардал гаргадаг тул тэд ажиллах хүчний хомсдолтой ч, дотоодод тэдгээр ажиллах хүчний шаардлагад нийцэх дотоодын ажилтан байхгүй ч гадаадаас ажилтан чадахгүйд хүрч байна гэж хэлж болно. Ажил олгогчдын үүрэх зардлаас дурдвал, мэдээж банк, банк бус санхүүгийн байгууллагаас авсан зээлийн үндсэн төлбөр, түүний хүү төлөх, орлогын албан татвар, холбогдох хуульд заасан татвар, хураамж, ажил олгогчийн зүгээс төлөх нийгмийн даатгалын шимтгэл, мөн үйл ажиллагаа, цалин хөлсний зардал гэх мэт. Түүнчлэн ажил олгогч гадаад ажилтан ажиллуулах бүрд бүртгэлтэй ажилгүй иргэнийг дагалдуулж сургах, гадаад ажилтныг хуульд заасан сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах, ажлын байрны төлбөр төлөх зэрэг зардал бий болгох Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд заасан олон үүргүүдийг биелүүлэх болдог. Үүнээс гадна, ажил олгогчийн урилгаар ирсэн гадаадын иргэдийн визтэй холбоотой төлбөр, хураамжийг ажил олгогч өөрөө төлнө. Гэтэл ажиллах хүчний хомсдолд орсон нийт 48,900 аж ахуй нэгжүүдийн дийлэнх нь буюу 45,700 нь хувийн хэвшлийн аж ахуй нэгжид байснаас 85.8 хувь болох 39,200 нь 30 хүртэлх ажилтантай жижиг² болон бичил аж ахуйн нэгж, мөн үүнээс 66.2 хувь буюу 25,950 нь 9 хүртэлх ажилтантай бичил аж ахуй нэгжүүдэд³ хамаарах ажиллах хүчний хомсдол байгааг анхаарах шаардлага бий болсон байна;

3/Түүнчлэн энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын 2-т зааснаар эрчим хүчний сэргэлтийн бодлогын хүрээнд эрчим хүчний салбарыг эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шижлүүлж, үнэ тарифыг чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэхээр байгаа цаг мөчид ажиллах хүчний хомсдол мөн дээрээс нь бизнес эрхлэгчдэд эрчим хүчний үнэ тарифыг чөлөөлөхтэй холбоотой

² "жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг ойлгоно: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт. /Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2019 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

³ "бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг ойлгоно: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт.

нэмэлт зардлууд бий болгох тул тодорхой богино хугацаанд гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг чөлөөлөх нь цаг үеэ олсон шийдэл байхаар байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг санаачлан боловсруулсан болно.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан урьдчилан тандан судалгаа, харьцуулсан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан, хууль тогтоомжийн үр нөлөөний судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хөндлөнгийн багаар хийлгүүлж, зөвлөмжийг тусган ажиллалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах болон энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд энэ хуулийн 12.1.4-т заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалыг баримталж болно.” гэж заасны дагуу тус хуулийн төсөлтэй холбогдуулан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал үүсэхгүй тул тусдаа зардлын тооцоо хийх шаардлагагүй болно.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт цахим хуудсанд байршуулсан болно.

---oOo---